



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 469

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Орхон АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 121,317,724.00 /нэг зуун хорин нэгэн сая гурван зуун арван долоон мянга долоон зуун хорин дөрвөн/ төгрөгийн балансын үнэ, 106,532,760.00 /нэг зуун зургаан сая таван зуун гучин хоёр мянга долоон зуун жаран/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий зөөврийн асфальт заводыг “Архангай АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, “Архангай АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ю.Ганзориг, “Орхон АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Цогтгэрэл нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Авсан арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



0000971

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн
469 дугаар тогтоолын хавсралт



"Орхон АЗЗА" төрийн өмчит хувьцаат компаниас
"Архангай АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанид
балансаас балансад шилжүүлэх хөрөнгө

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Зөөврийн чулуу бутлагч	2009	17,829,903.00	16,080,166.00	1,749,737.00
2	ЗА бетон завод	2009	60,918,837.00	52,795,714.00	8,123,123.00
3	Битум чанагч	2009	42,568,984.00	37,656,880.00	4,912,104.00
	Нийт дүн		121,317,724.00 /нэг зуун хорин нэгэн сая гурван зуун арван долоон мянга долоон зуун хорин дөрвөн/	106,532,760.00 /нэг зуун зургаан сая таван зуун гучин хоёр мянга долоон зуун жаран/	14,784,964.00 /арван дөрвөн сая долоон зуун наян дөрвөн мянга есөн зуун жаран дөрвөн/